



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/292

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийн 4 дүгээр бүлгийн 4.1.1 дэх зорилт, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.1 дэх зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Газар тариалан, жимс жимсгэнэ" төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдэх жимс жимсгэний талбай хашиж торлох бараа материал хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Г.Хурцгэрэл -(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Б.Пүрэвжав -(Хүнс, хөдөө аж ахуйн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн)

Н.Баярмаа -(Хүнс, хөдөө аж ахуйн газрын архив, албан хэрэг хөтлөлт, нярав)

Б.Балдорж -(Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:С.Баярмаа -(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хүнс, хөдөө аж ахуйн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

2.Нийлүүлэгдсэн хашлага хамгаалалтын бараа материалыг хүлээн авч, сумдад хуваарилан олгох ажлыг шуурхай зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Хурцгэрэл)-д даалгасугай.

ОРЛОГЧ Д.АЛТАНЗАГАС